



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/237

Булган сум

**“Хүүхэд хамгааллыг хамтдаа хөгжүүлье”
арга хэмжээг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.4 дэх заалт, Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2022 оны А/571, А/637, А/218 тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хөдөө орон нутагт эрчимжүүлэх, хүүхдэд чиглэсэн нийгмийн суурь үйлчилгээг хурдан шуурхай хүргэх зорилгоор “Хүүхэд хамгааллыг хамтдаа хөгжүүлье” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2.“Хүүхэд хамгааллыг хамтдаа хөгжүүлье” арга хэмжээний ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ерөнхий удирдамжийг 2 дугаар, шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 992,520 (есөн зуун ерэн хоёр мянга таван зуун хорь) төгрөгийг аймгийн хүүхэд хамгааллын хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтийг ханган ажлын хэсгийн аюулгүй байдалд анхаарч ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга (Т.Баярбат)-д үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА


БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024. оны
01 дүгээр сарын 10-ний өдрийн А/237 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

**"ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ ХАМТДАА ХӨГЖҮҮЛБЭ"
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

- Ажлын хэсгийн ахлагч: Т.Баярбат (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга)
- Гишүүд:
- А.Оюунжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
 - С.Оюунзаяа (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын ахлах мэргэжилтэн)
 - Г.Гандолгор (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн)
 - Н.Хулан (Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн)
 - М.Ариунаа (Нэгдсэн эмнэлгийн шүдний эмч)
 - Б.Оюун-эрдэнэ (Нэгдсэн эмнэлгийн шүдний эмчийн туслах)
 - Г.Мөнгөнтуяа (Төв номын сангийн эрхлэгч)
 - Д.Лодойдамба (Аймгийн Хүүхдийн зөвлөлийн тэргүүн)
 - Т.Ивээлжаргал (Аймгийн Хүүхдийн зөвлөлийн дэд тэргүүн)
- Нарийн бичгийн дарга: Б.Мягмарсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

ОН дүгээр сарын 10-ний өдрийн А.237 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ”
АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Үндэслэл:

2023 оны жилийн эцсийн бүртгэл судалгаагаар аймгийн хэмжээнд нийт 19069 өрхийн 61717 хүн ам оршин сууж байна. Үүнээс 0-17 насны хүүхэд 21039 буюу нийт хүн амын 34%-г эзэлж байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн 801 нь хагас өнчин, 36 нь бүтэн өнчин хүүхэд байна.

Нийт хүүхдүүдийн 53.8% нь ерөнхий боловсролын сургуульд, 17.8% нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд, 0.5% нь насан туршийн боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа бөгөөд дээрх хүүхдүүдийн 0.8%-ийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эзэлж байна.

Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих чиглэлээр аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэнд, Шинэ ирээдүй, Хүүхэд хамгаалал, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилласнаар хүүхдийн “Жаргалант” зуслангийн барилгын ажлыг эхлүүлсэн, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төв болох “Түр хамгаалах байр”-ыг ашиглалтад оруулаад байна.

Хүүхдийн хөгжил оролцоог дэмжин, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж байгаа хэдий ч гэмт хэргийн улмаас хохирсон, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо жил бүр өсөх хандлагатай байна. Тухайлбал: 2023 оны жилийн эцсийн статистик судалгаагаар эрсдэлийн программд бүртгэлтэй 425, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд 35, гэмт хэрэгт холбогдсон хүүхэд 12, түр хамгаалах байраар үйлчилгээ авсан хүүхэд 43, кейс нээж ажилласан 137 хүүхэд байна.

Аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд байнгын асаргаатай хүүхдийн тоо тасралтгүй өсөж байгаа бөгөөд 3 жилийн хугацаанд 78 хүүхэд шинээр асаргаа тогтоолгон нийт хүүхдийн тоо 237 болсон нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 9.9%-ийг эзэлж байна. Асаргаатай хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл хэлбэрийг авч үзэхэд 2 ба түүнээс дээш хавсарсан эмгэгтэй болон оюун ухааны хомсдол, сэтгэцийн эмгэгтэй хүүхдүүд дийлэнх нь байна.

Өнгөрсөн онд аймгийн хэмжээнд зохион байгуулсан "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" амны хөндийн өвчлөлийг илрүүлэх үзлэгт 13247 хүүхдийг хамруулсны 90% нь шүд цоорох өвчтэй байсан бөгөөд хүүхдүүдийн амны хөндийг эмчлэн эрүүлжүүлэх асуудал тулгамдаж байна.

Мөн боловсролын салбарт багш сурагчдын хоорондын ёс зүйн харилцаа хандлагын зөрчил, мэргэжлийн багш, нийгмийн ажилтны дутагдал, дотуур байрны хүүхдүүдийн хөгжлийн өрөө дутмаг, үе тэнгийн дарамт, гадуурхалт, хичээлээс гадуурх хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа дутмаг зэрэг асуудлууд гарсаар байна.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, салбар дундын уялдааг бэхжүүлэн, хүүхдэд тулгамдаж байгаа асуудлуудад чиглэсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нэг дороос хурдан, шуурхай

хүргэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Зорилго:

Сум орон нутаг болон хөдөөгийн алслагдсан багт амьдарч байгаа хүүхдүүдэд чиглэсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг (эрүүл мэнд, халамж, боловсрол, хүүхэд хамгаалал) нэг дороос хурдан, шуурхай хүргэх замаар нийгмийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааны давхардал, үр ашиггүй байдлыг багасгахын зэрэгцээ тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулахад оршино.

Зохион байгуулагч:

- Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл (БШУГ, ЭМГ, ХХҮГ, аймгийн Номын сан)
- Хүүхдийн нэгдсэн зөвлөл
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс

Хамрах хүрээ:

Хишиг-Өндөр, Могод сумын ЕБС-ийн сурагчид, ЕБС-д үйл ажиллагаа явуулдаг Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, Дотуур байрны хүүхдүүд, СӨБ-д хамрагдаж буй хүүхдүүд, тусгай хэрэгцээт хүүхдүүдийг хамруулна.

Хугацаа:

2024 оны 04 дүгээр сарын 11-нээс буюу 2 дугаар улирлаас – 2024 оны 4 дүгээр улирал хүртэл ажиллана. 1 дүгээр ээлжинд ажиллах сумдын хуваарь:

Хишиг-Өндөр суманд – 2024 оны 04 дүгээр сарын 16-17-ны өдөр
Могод суманд – 2024 оны 04 дүгээр сарын 18-19-ний өдөр

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

Хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр хийгдэх ажил:

- Аймгийн хүүхдийн зөвлөлийн удирдах зөвлөлийн хүүхдүүд 4 бүсэд хуваагдан хичээл сургалтын ажилд оролцож “Сурагч солилцоо”-г зохион байгуулах
- Монголын хүүхдийн парламентаас зохион байгуулж буй “Хүрээлэн буй орчны бохирдол” санал асуулга авах
- Сумдын удирдлагуудтай хамтран “Хүүхдээ сонсьё” арга хэмжээг зохион байгуулж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх
- Сум бүрд хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, хүүхэд өсвөр үеийнхний төлөө ажиллах “Хүүхдийн элч”-ийг сонгох
- Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, хүүхдийн зөвлөлийн 2023-2024 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах
- Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн талаар үе тэнгийнхэнд зориулсан “Хамтдаа хөгжье” сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, мэдээллээр хангах
- Аймгийн хэмжээнд дотуур байрны хүүхдүүдийн судалгаа гаргаж, хүүхэд хөгжлийн өрөөг тохижуулах ажилд хүүхдүүдээс санал авах
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг шинэчлэн гаргах
- Сумдын удирдлагууд, сумын нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтнуудтай уулзалт, ярилцлага хийх.

Нийгмийн халамж, эрүүл мэндийн чиглэлээр хийгдэх ажил:

- Сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн, халамжийн мэргэжилтнүүдтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн статистик тоон мэдээллийг шинэчлэх (Байнгын асаргаатай болон, боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй хүүхдийн тоо, ЕБС-д суралцдаг, СӨБ-д хамрагдаж буй хүүхдийн тоо) ажлыг зохион байгуулах
- Хэвтрийн болон байнгын асаргаатай хүүхдүүдэд гэрийн эргэлт хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд болон асран хамгаалагчдад тулгамдаж байгаа асуудлуудыг сонсож, бодлого төлөвлөлтөд тусгах, хэвтрийн болон байнгын асаргаатай хүүхдүүдэд гэрийн эргэлт хийх.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг сум бүрд ажиллуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, асран хамгаалагчдын дархлааг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах
- ЕБС-ийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн болон СӨБ-ын байгууллагын хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй, шим тэжээлийн хангалттай байдалд үнэлгээ хийх.
- 16 сум 1 тосгонд 2-17 насны хүүхдүүдийн насны онцлогт тохирсон аргачлалаар шүд цоорох өвчний хор уршиг, шүдээ зөв угаах дадал олгох сургалтыг зохион байгуулах
- Шүд цоорох өвчтэй сурагчдыг эмчлэх, эрүүлжсэн арга хэмжээг хэрэгжүүлэх
- Явуулын номын сангийн цогц үйл ажиллагааг сум орон нутгийн хүүхэд өсвөр үе, иргэд олон нийтэд хүргэх
- НҮБ-ын хүүхдийн сангаас орон нутагт ирүүлсэн хандив тусламжийг сумдын зорилтот өрхийн болон, зудын бүсэд байгаа хүүхдүүдэд хүргэх

Хүрэх үр дүн:

- ЕБС-ийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн болон СӨБ-ын байгууллагын хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй, шим тэжээлийн хангалттай байдалд үнэлгээ хийгдэж, зөвлөмж өгсөн байна.
- Сумдын хүүхдүүдийн “Хүүхдээ сонсьё” арга хэмжээг зохион байгуулагдаж, арга хэмжээнээс гарсан саналууд шийдвэрлэгдсэн байна
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд болон асран хамгаалагчид, хэвтрийн болон байнгын асаргаатай хүүхдүүдэд гэрийн эргэлт хийгдэж, тулгамдаж буй асуудлыг нэгтгэн бодлого төлөвлөлтөд тусгах, сум орон нутгаас хамааралтай шийдэж болох асуудлуудыг шийдвэрлэсэн байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн статистик тоон судалгаа шинэчлэгдсэн байна.
- ЕБС-ийн сурагчдад болон ХӨУБ-ын хүүхдүүдэд тусгай хэрэгцээт хүүхдүүдийн талаарх мэдлэг олгогдсон байна.
- 16 сум 1 тосгонд 2-17 насны хүүхдүүд шүд цоорох өвчний хор уршгийн талаар мэдлэгээ тэлж, шүдээ зөв угаах дадалд суралцсан байна.
- Амны хөндийн өвчлөлийг илрүүлэх үзлэгт 13247 хүүхдийг хамруулсны 90% нь шүд цоорох өвчлөлтэй хүүхдүүдийн 50%-д хүрч эмчилсэн байна.
- Дотуур байрны хүүхдүүдийн судалгаа шинэчлэгдэж, охид ба хөвгүүдэд зориулсан жишиг хөгжлийн өрөөг шаардлагатай сумдад байгуулагдсан байна.
- Дотуур байрны охид болон сургуулийн эмэгтэй бие засах өрөөнд “Нандин хайрцаг” –ийг технологийн багш нартай хамтран байршуулсан байна.
- Явуулын номын сангийн цогц үйл ажиллагааг сум орон нутгийн хүүхэд өсвөр үеийнхэнд хүрч ажилласан байна.

- Аймгийн хүүхдийн зөвлөлийн удирдах зөвлөлийн хүүхдүүд 4 бүсэд хуваагдан хичээл сургалтын ажилд оролцож “Сурагч солилцоо” зохион байгуулагдаж, сумын ХӨУБ-ын хүүхдүүд чадваржиж, шинэ шинэлэг ажлуудыг өрнүүлсэн байна.
- НҮБ-ын хүүхдийн сангаас орон нутагт ирүүлсэн хандив тусламжийг сумдын зорилтот өрхийн болон, зудын бүсэд байгаа хүүхдүүдэд хүргэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 10-ний өдрийн А/237 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ ХАМТДАА ХӨГЖҮҮЛБЭ”
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
	Булган – Хишиг-Өндөр (80 км + 150 км) → Хишиг-Өндөр – Могод (70 км + 150 км) → Могод – Булган (150 км) = 300 км =1150 км				
1	Шатахууны зардал (1 машин 550 км)	Л	132	2,520	332,640
	Шатахууны зардал (1 машин 300 км)	Л	48	2,520	120,960
	Шатахууны зардал (1 машин 300 км)	Л	48	3,910	187,680
	Шатахууны зардал (1 машин 300 км)	Л	54	2,520	136,080
2	Хулдаасан хэвлэл	М ²	13	16,600	215,160
Нийт					992,520